

“МОНГОЛ, ХЯТАДЫН ХАРИЛЦААНД ӨВӨР МОНГОЛЫН ҮҮРЭГ, ХОЛБОГДОЛ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛОВ

2004 оны 10-р сарын 1-нд БНХАУ байгуулагдсаны ойн баярыг тохиолдуулан ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Хятад судлалын тасаг, БНХАУ-ын Өвөр Монголын Зүүн Хойд Ази Судлалын Хүрээлэнтэй хамтарч “Монгол, Хятадын харилцаанд Өвөр Монголын үүрэг, холбогдол” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав. Эрдэм шинжилгээний хуралд Монгол Улсын ГХЯ-ны Хөрш орнуудын газрын дарга О.Энхтөр, ҮХЯ-ны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга Д.Галсандорж, Монголын энх тайван, аюулгүй байдал, олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ерөнхийлөгч Д.Цахилгаан, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны зөвлөх Ван Фукан, Өвөр Монголын Зүүн Хойд Ази Судлалын Хүрээлэнгийн (ЗХАСХ) зөвлөх Насан, дэд захирал Лю Хунру, МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн захирал Н.Алтанцэцэг, МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийн захирал Д.Наран, ӨМИС-ийн Хөрш орнуудын судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Үрцэцэг болон Стратегийн судалгааны хүрээлэн, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд оролцов.

Эрдэм шинжилгээний хурлыг ОУСХ-ийн захирал, доктор Л.Хайсандай нээж, удирдан явуулав. Тэрбээр хуралд оролцогсдыг танилцуулан, илтгэгч нарт амжилт хүсээд, тус хүрээлэн Өвөр Монголын Зүүн хойд Ази судлалын хүрээлэнтэй олон жил үр бүтээлтэй хамтран ажиллаж буйг онцлон тэмдэглэлээ. Хуралд ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Ч.Батцэцэг “Монгол, Хятадын харилцаанд Өвөр Монголын үүрэг, холбогдол” сэдвээр, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн ахлах мэргэжилтэн Д.Начин “БНХАУ-аас Монгол Улсын уул уурхайн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт” сэдвээр, ӨМИС-ийн Хөрш орнуудын судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Үрцэцэг “Даяаршил ба Монголын эдийн засаг” сэдвээр илтгэл тавилаа. Доктор Ч.Батцэцэг илтгэлдээ Монгол, Хятадын харилцаанд Өвөр Монголын үүрэг, холбогдлыг гаргахын тулд 90-ээд оноос хойш эдүгээ хүртэлх хоёр улсын харилцаа, түүний дотор Өвөр Монголын хамтын ажиллагааг бүхий л салбараар, тодорхой баримт жишээнд тулгуурлан, тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан бичсэн нь чухал ач холбогдолтой болсон юм. Тэр илтгэлдээ улс төрийн харилцааны тухайд Монгол Улсад албан ёсны айлчлал хийх БНХАУ-ын төр засгийн тэргүүн нарын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ӨМӨЗО-ы удирдлагаас заавал багтдаг

бол Монгол Улсын тэргүүн, ерөнхий сайд болон бусад албаны хүмүүс БНХАУ-д айлчлах үеэр ӨМӨЗО-оор зочилдог сайхан уламжлал нэгэнт тогтсон нь Монгол, Хятадын хоёр талын харилцаанд ӨМӨЗО ямар байр суурьтайг тодорхойлж байна гэжээ.

Нөгөөтэйгүүр орчин үеийн олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд бүс нутгийн асуудал зонхилж байгаатай уялдан бүс нутгийн хөгжилд ялангуяа хөрш орнуудын хамтын ажиллагааг дэмжих явдлыг чухалчилах, харилцан бие биенээ нөхөн, дутуугаа гүйцээн хөгжих асуудал эрчимжиж байна. Энэ нь манай хоёр орны харилцан ашигтай, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байна. Зөвхөн ганц жишээ дурьдахад, БНХАУ-ын статистикийн мэдээгээр сүүлийн жилүүдэд Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы худалдааны нийт хэмжээ Монгол, Хятадын худалдааны 49,2%-ийг эзэлж, Өвөр Монголын импортын хэмжээ нь Хятад улсын импортын хэмжээний 62%-ийг эзлэх болжээ. Манай уул, уурхайн салбарт Хятадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, Өвөр Монголын томоохон корпораци, компаниуд хамтран ажиллах болов. Тухайлбал: Өвөр Монголын Цинхуа корпораци манай улсын Нарийнсухайтын нүүрсний уурхайд, Бугатын болд төмрийн үйлдвэр Төмөртийн уурхайд, Синхуа корпораци Тавантолгойн нүүрсний уурхайд хамтран ажиллахаар төсөл хэрэгжүүлж эхлэв.

Хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд бүс нутгийн хилийн худалдаа чухал үүрэг гүйцэтгэж ирлээ. Өнөөдөр Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы хооронд хилийн 7 боомт ажиллаж байна. Манай хоёр орны соёл, боловсрол, шинжлэх ухаан, биеийн тамир, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах салбарын хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин тэлсээр байгааг илтгэгч цохон тэмдэглэв.

Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар БНХАУ-ын дарга Ху Цзиньтао манай оронд айлчлах үеэр “ӨМӨЗО-ыг хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд гүүрийн үүрэг гүйцэтгэхийг дэмжинэ” хэмээн Хятад, Монголын харилцаанд ӨМӨЗО-ы эзлэх байр суурийг тодорхойлсон юм.

Доктор Ч.Батцэцэг Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы харилцаа, хамтын ажиллагааг бүс нутгийн шинжтэй болгон хөгжүүлэх үүднээс 1-рт, бүс нутгийн түншлэлд газарзүйн байрлал, хэл, соёл, уламжлал чухал үүрэг гүйцэтгэх; 2-рт, хөрөнгө оруулалт, хуул зүйн орчинг бүрдүүлж, дэд бүтцийг хөгжүүлэх; 3-рт, хил, гаалийн албанд таатай уур амьсгал бүрдүүлж, хилийн худалдааны үйл ажиллагааг эрчимжүүлэн хоёр талын хилийн худалдаа, экспорт, импортын барааны чанарыг сайжруулах; 4-рт, хоёр талын аймаг, хот, сум хоорондын харилцаа холбоог илүү

чухалчилж, орон нутгийн удирдлагын эрх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх; 5-рт, орон нутгийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлж, хилийн зарим боомтыг олон улсын зорчигч, ачаа тээврийн боомт болгох, хилийн ойролцоо байгаа аялал жуулчлалын баазуудыг түшиглэх, шинээр байгуулж жуулчин солилцох гэх мэт хэд хэдэн санал дэвшүүлээ.

Эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаа эрдэмтэд санал солилцож, асуулт хариултаар үргэлжлэв. Тухайлбал: доктор Л.Жамсран: Өвөр Монголыг Монгол, Хятадын харилцаанд гүүр болгож байгаа тухай ярьж байна. Хятадын бусад өөртөө засах орныг ийм гүүр болгож байна уу?

Өвөр Монголын ЗХАСХ-ийн зөвлөх Насан: Нэгдүгээрт, Монгол Улс Өвөр Монголтой нийт 4600 км нутгаар хиллэдэг. Хилийн 10 боомтын 7 нь Өвөр Монголд байна. Үүнээс улбаалан Хятад улс Монголтой харилцахад гол нь газарзүйн байрлал чухал. Хоёрдугаарт, монгол үндэстэн олон учраас хэл, соёлын адил төстэй талыг харгалзан ийм бодлого явуулж байна. Синьцзян Уйгурын Өөртөө Засах Орон мөн Дундад Азийн орнуудад гүүр болох талтай ч одоогоор албан ёсоор тийм нэр томъёо хэрэглээгүй байгаа.

Доктор Ч.Батцэцэг: Хятадын баруун бүсийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд ӨМӨЗО-ыг багтааж, хөрөнгө оруулалтыг ихээр татаж байгаа. Хөрөнгө оруулалтыг дагалдан хятад үндэстний мэргэжилтэн, инженер техникийн ажилтнууд Өвөр Монголд олноороо ирж байна. Тэд цаашдаа Өвөр Монголын хүн амын бүрэлдэхүүнд орж тоологдох уу?

Насан: Тийм ээ, мэргэжилтэй боловсон хүчин маш их ирж байгаа. Тэд нар Өвөр Монголын хүн амын бүрэлдэхүүнд багтана гэж хариулав. Мөн бусад олон эрдэмтэн сонирхолтой асуулт тавьж, тодорхой хариултыг авлаа.

Хятадын эрдэмтэд Хятад, Монголын харилцаанд ӨМӨЗО-ы үүрэг холбогдлын талаар өөрсдийн судалгаанаас танилцуулан, ЗХАСХ-ийн зөвлөх Насан хурлын илтгэлүүдэд үнэлэлт дүгнэлт өгч, эрдэм шинжилгээний гүнзгий судалгаа хийсэн чухал илтгэл тавьсанд баяр хүргээд, нутагтаа авч очоод хэвлүүлнэ гэдгээ мэдэгдэв. Улмаар эдийн засгийн даяаршил явагдаж буй өнөөгийн нөхцөлд улс үндэстэн бүр өөрийн байр сууриа хадгалан үлдэх талаар голлон анхаарч байна. Улс орон бие даан үлдэх боломж тун бага учраас хөрш орнуудын эдийн засгийн болон бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал чухал болж байна. Ийм нөхцөлд манай хоёр хүрээлэн Монгол, Хятадын хамтын ажиллагаанд гүүрийн үүрэг гүйцэтгэж байна гэж би бодож байна. Цаашдын хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэх болно гэв.